



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 02 дугаар сарын 24

№ 01/55 ДУА-2018/5/СТА-ТТЗ

Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Хулд сумын тусгай зориулалтын сангуудын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар сангийн хөрөнгийг бусдад санхүүжилт хэлбэрээр олгож, зориулалт бусаар зарцуулсан 23,000,000.00 төгрөгийн зөрчил илэрсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 24.4-т /Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно/, 25.10-т /Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно/, Засгийн газрын 188 дугаар тогтоолоор баталсан "Байгаль хамгаалах сан байгуулах, зарцуулах журам"-ын 10-т /Сангийн хөрөнгийг дор дурдсан зориулалтаар зарцуулна: а/байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхэд хөрөнгийн дэмжлэг үзүүлэх .../ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.5-д /Байгууллага гэрээ, хэлцэл мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлага, нөхцлийг хангаагүй / заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Сангийн хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх;
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Төрийн аудитын газарт 2018 оны 03 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийн Хулд сумын Засаг дарга Ч.Зоригтбаатар, нягтлан бодогч Ч.Хүүхэнбаатар нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:
АУДИТОР  Ж.УГТАХБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:
ДАРГА  Ч.ЗОРИГТБААТАР
НЯГТЛАН БОДОГЧ  Ч.ХҮҮХЭНБААТАР

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангаагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.